

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтэс
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШҮ
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ									
1.1.	Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг улс, бүс, орон нутаг, салбар хоорондын уялдааг ханган боловсруулах, хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төлөвлөлтийг хийх, хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг	-	Улсын дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан байх	Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолын хавсралтаар “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө” батлагдсан.	Улсын дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан байх		Монгол Улсын Үндсэн Хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.” гэж, Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Засгийн газар Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг Улсын Их Хурлаас тогтоосон, эсхүл хуульд заасан хугацаанд, Засгийн газрын үйл ажиллагааны	100%	90%

67

	хангах, нэгдсэн бодлогыг тодорхойлн					хөтөлбөрийн төслийг өөрийн бүрэн эрх эхэлснээс хойш 60 хоногийн дотор, ...хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд тус тус өргөн мэдүүлнэ.” гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт “Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2024- 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан. “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хамтарсан Засгийн газрын гэрээг удирдлага болгон 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд дэвшүүлсэн Монгол		
--	---	--	--	--	--	--	--	--

						Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын мөрийн хөтөлбөрт суурилсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулж,Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанд танилцуулж, мөн Засгийн газрын 08 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын чуулганы 08 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав. Монгол Улсын Үндсэн Хууль, холбогдох хуулиудад заасны дагуу “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулж, Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар 2024 оны 09 дүгээр		
--	--	--	--	--	--	--	--	--

							сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлууллаа.		
1.1.1	Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан төслийн эхний хувилбарыг боловсруулна.	-	Боловсруулах бодлогын баримт бичгийн тоо	Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын хавсралтаар "Шинэ сэргэлтийн бодлого" батлагдсан.	-	Хөгжлийн 6 зорилтот хөтөлбөрийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан байна. /Нийт 6 бодлогын баримт бичиг/	Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслүүдийг боловсруулах ажлын хүрээнд Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр, Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, Байгаль орчны зорилтот хөтөлбөр, Засаглалын зорилтот хөтөлбөр, Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөрийн төслүүдийг сайжруулж, эхний хувилбарыг боловсруулж ажилласан.	100%	100%
1.1.2	"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн төслийг	-	Боловсруулах төлөвлөлтийн баримт бичгийн тоо	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар "Монгол Улсын Засгийн газрын	-	"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн төслийг	Монгол Улсын Үндсэн Хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад "Хөгжлийн бодлого, төлөвлөлт	100%	100%

	боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ.			2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” батлагдсан		боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. /Нийт 1 төлөвлөлтийн баримт бичиг/	тогтвортой байна.” гэж, Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Засгийн газар Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг Улсын Их Хурлаас тогтоосон, эсхүл хуульд заасан хугацаанд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг өөрийн бүрэн эрх эхэлснээс хойш 60 хоногийн дотор, ...хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд тус тус өргөн мэдүүлнэ.” гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт “Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2024-		
--	---	--	--	--	--	--	--	--	--

							2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан. “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хамтарсан Засгийн газрын гэрээг удирдлага болгон 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд дэвшүүлсэн Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын мөрийн хөтөлбөрт суурилсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулсан бөгөөд “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Хүний хөгжлийн бодлого”, “Эдийн засгийн бодлого”, “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн 4 бодлогын чиглэлийн хүрээнд 16 зорилго, 62 зорилт, түүнийг хэрэгжүүлэх 593 үйл ажиллагааг тусгалаа. Хуульд заасны дагуу "Засгийн газрын		
--	--	--	--	--	--	--	--	--	--

						2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанд танилцуулж, мөн Засгийн газрын 08 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын чуулганы 08 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.			
1.1.3	Богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг буюу "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж,	-	Боловсруулах төлөвлөлтийн баримт бичгийн тоо	Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолын хавсралтаар "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө" батлагдсан.	-	"Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. /Нийт 1 төлөвлөлтийн баримт бичиг/	Монгол Улсын Үндсэн Хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад "Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна." гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь хэсэгт "...4.1.13-	100%	100%

	УИХ-д өргөн мэдүүлнэ.						д заасан баримт бичгийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасныг тус тус баримтлан батлах;" гэж тус тус заасны дагуу "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан. Хамтарсан Засгийн газрын "Хурдтай хөгжлийн төлөөх зориг" гэрээг удирдлага болгон "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-г Эдийн засаг, Бүсчилсэн хөгжил, Хүний хөгжил, Хүний эрхийг дээдэлсэн засаглалын гэсэн 4 үндсэн бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд "Урт хугацааны тогтвортой хөгжлийг		
--	--------------------------	--	--	--	--	--	--	--	--

						хангах суурийг бэхжүүлэх” зорилгыг тодорхойлж, дэд бүтэц, бүтээн байгуулалтын 14 мега төсөл, тогтвортой хөгжлийг хурдасгах 149 төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж, салбарын реформуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний төсөлд нийт 314 төсөл, арга хэмжээг 19.2 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгалаа. Үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 5.2 их наяд төгрөг, гадаадын зээл, тусламжаар 4.2 их наяд төгрөг, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар 4.1 их наяд төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэлээр 4.1 их наяд төгрөг, бусад эх үүсвэрээр 1.5 их наяд төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр		
--	--	--	--	--	--	--	--	--

							тусгасан. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний төслийг Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлуулна.		
1.1.4	"Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна.	-	Боловсруулах төлөвлөлтийн баримт бичгийн тоо	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын хавсралтаар "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" батлагдсан.	-	"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан байна. /Нийт 1 төлөвлөлтийн баримт бичиг/	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолыг үндэслэн "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төслийг яамд, байгууллагуудаас ирүүлсэн материалд	100%	100%

							үндэслэн нэгтгэн боловсрууллаа. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний төсөлд яамд, байгууллагуудаас нийт 1,592 төсөл, арга хэмжээний санал ирүүлснээс 203.9 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 1,511 төсөл, арга хэмжээг тусган ажиллаж байна. Үүнээс 2025 онд 40.7 их наяд төгрөг, 2026 онд 53.5 их наяд төгрөг, 2027 онд 57.6 их наяд төгрөг, 2028 онд 52.1 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдахаар байна.		
--	--	--	--	--	--	--	--	--	--

1.2.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж улс, бүс, орон нутаг, салбар хооронд нэгтгэн зохион байгуулах, уялдааг хангах, арга зүйн зөвлөгөө өгнө.	-	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж улс, бүс, орон нутаг, салбар хооронд нэгтгэн зохион байгуулах, уялдааг хангах, арга зүйн зөвлөгөө өгсөн байх	-	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж улс, бүс, орон нутаг, салбар хооронд нэгтгэн зохион байгуулах, уялдааг хангах, арга зүйн зөвлөгөө өгсөн байна.		Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох журмын хүрээнд аймаг, нийслэл, хотын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал, зөвлөмж өгч ажиллав. Мөн аймгуудын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд санал өгч ажиллалаа.	100%	100%
1.2.1	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд шаардагдах журмын төслийг боловсруулна.	-	Боловсруулах журмын төслийн тоо	Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/167 дугаар тушаалаар "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал" баталсан.	-	Холбогдох журмын төслийг боловсруулсан байна. /Нийт 1 журмын төсөл/	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд шаардагдах журмын төслийг боловсруулах ажлын хүрээнд "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар аргачлалын төсөл болон "Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны	100%	90%

							хөтөлбөр боловсруулах аргачлал", "Монгол улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын төслийг сайжруулан боловсруулж байна. Журмын төсөлд яамны зохион байгуулалтын нэгжүүдээс саналыг авч нэгтгэн, сайжруулж ажилласан.		
1.2.2	Нийгмийн тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангана.	-	Бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангасан байх, хувиар	-	Бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангасан байна.	Бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангасан байна.	Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл нь "урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах суурийг бэхжүүлэх" бөгөөд "Эдийн засаг", "Бүсчилсэн хөгжил", "Хүний хөгжил", "Хүний эрхийг дээдэлсэн засаглал" гэсэн тэргүүлэх чиглэлийн хүрээнд өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудлуудад үндэслэн тодорхойлж,	100%	90%

							шаардлагатай салбарын реформыг шуурхай эхлүүлж, тэргүүлэх ач холбогдолтой хөгжлийн томоохон төслүүдийг эрчимжүүлэхийг зорьсон. Эдийн засгийн бодлогын хүрээнд урт хугацааны тогтвортой хөгжлийн суурь дэд бүтцийг бий болгох 14 мега төслийг 2025 онд бүрэн эхлүүлж, макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, зах зээл дэх төрийн оролцоог хялбарчлах, салбаруудад бодлогын цогц реформыг хийх шинэчлэлийн ажлуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгасан. Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг дэмжих, иргэн бүр тэгш		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							эрхтэйгээр нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах, орлого олох, хөгжих боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн гэр бүл, хүүхэд, эхчүүд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан, залуучуудын онцлогт нийцүүлсэн бодлогыг хэрэгжүүлэхээр тусгасан.		
1.2.3	Хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангана.	-	Бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангасан байх, хувиар	-	Бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангасан байна.	Бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангасан байна.	Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн "Хүний хөгжлийн бодлого" хоёрдугаар бүлэгт "Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлан хөгжих, суралцах, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлж, чинээлэг, баялагтаа эзэн, эрдэм боловсролтой, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ" зорилгыг тусгаж, гэр бүл, хүүхэд, эхчүүд, эмэгтэйчүүд зэрэг	100%	90%

							бүлгүүдэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн баталгаа, эрүүл мэнд, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр 134 зорилт, арга хэмжээг төлөвлөн, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор батлуулсан. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гуравдугаар бүлэгт Хүний хөгжлийн бодлогыг тусган өвчлөл, нас баралтыг бууруулах, боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, түүх,		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зэргээр хөтөлбөрийн 15 үр дүн, 58 төсөл, арга хэмжээг тусган, Монгол Улсын Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлуулсан.		
1.2.4	Монгол Улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгнө.	-	2025 оны улсын төсвийн төсөлд зөвшөөрөл өгсөн байх	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар 2023 онд зөвшөөрөл өгсөн.	-	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд нийцсэн эсэхийг нягтлан шалгаж, зөвшөөрөл өгсөн байна.	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар 2024 оны 09 дүгээр сард зөвшөөрөл өгсөн.	100%	100%
1.2.5	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр	-	Хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулсан	Хүний нөөцийг чадавхжуулах сургалтыг тухай бүр зохион	Хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион	Хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулсан	Дараах хэлэлцүүлэг, семинарыг зохион байгуулав. Үүнд: 1. "Амлалтаас үйл	100%	90%

25

1	судалгаа шинжилгээ хийх мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах ажлыг зохион байгуулна.		байх, хувиар	байгуулсан.	байгуулсан байна. /100 хувь/	байна. /100 хувь/	ажиллагаанд: Монгол Улсын Үндэсний тодорхойлсон хувь нэмэр болон Хүлэмжийн хийн ялгарал багатай урт хугацааны хөгжлийн стратеги” семинарыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамтай хамтран 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулав. Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт болон Хүлэмжийн хийн ялгарал багатай урт хугацааны хөгжлийн стратеги (LT-LEDS) хоорондын үйл ажиллагааг уялдуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих замаар урт хугацааны стратегийг боловсруулахад олон талт оролцоо, цаашдын үр дүнтэй хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд		
---	--	--	--------------	-------------	------------------------------	-------------------	--	--	--

							дэмжлэг үзүүлсэн. 2. “Хүлэмжийн хийн ялгарлыг буруулах урт хугацааны үзэл баримтлал, стратегийн замын зураг боловсруулах төсөл”-ийн суурь тайлангийн үр дүн, дүгнэлтийг хэлэлцэх, санал солилцох Оролцогч талуудын зөвлөлдөх семинарыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, 2050 Патвейс платформ, Европын сэргээн босголт, хөгжлийн банкттай хамтран 2024 оны 05 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулав. Төр, хувийн хэвшлийн төлөөлөл, салбарын мэргэжилтэн, судлаачид болон хөгжлийн түншүүд идэвхтэй оролцож, төсөлд хэрэгцээтэй санал зөвлөмжийг нэгтгэх, цаашдын олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар санал солилцов. 3. “Тогтвортой		
--	--	--	--	--	--	--	---	--	--

						хөгжлийн зорилго” Үндэсний хэлэлцүүлгийг Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний байгууллагатай хамтран 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулав. НҮБ-ын “Ирээдүйн асуудлаарх дээд түвшний чуулга уулзалт”-д оролцох Монгол Улсын бэлтгэлийг хангах ажлын хүрээнд төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, залуучууд болон эрдэмтэн судлаачдын төлөөлөл оролцож, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгын хурдасгуур, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр санал, бодлоо солилцож, нэгдсэн санал, зөвлөмжийг НҮБ-ын “Ирээдүйн асуудлаарх дээд түвшний чуулга уулзалт”-д танилцуулах ач холбогдолтой байв.		
--	--	--	--	--	--	--	--	--

1.2.6	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал өгнө.	-	Мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал өгсөн байх, хувиар	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал өгсөн.	-	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал өгсөн байна. /100 хувь/	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал, зөвлөмж өгч ажиллав.Мөн Хэнтий, Говь-Алтай, Өмнөговь, Завхан зэрэг аймгуудын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд санал өгч ажиллалаа.	100%	90%
1.2.7	Эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэл болон эдийн засагт тулгарч болзошгүй эрсдэлт нөхцөл байдлыг тодорхойлох хүрээнд салбаруудын мэдээллийн бааз суурийг бэхжүүлж, бодлогын	-	Бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, салбаруудад бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан байх	-	-	Бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, салбаруудад бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан байна.	“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд Эдийн засаг, Бүсчилсэн хөгжил, Хүний хөгжил, Хүний эрхийг дээдэлсэн засаглалын гэсэн 4 үндсэн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, дэд бүтэц, бүтээн байгуулалтын 14 мега төсөл, тогтвортой хөгжлийг хурдасгах 149 төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж, салбарын	100%	90%

	дэмжлэг үзүүлж ажиллана.						реформуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Эдийн засгийн бодлогын хүрээнд урт хугацааны тогтвортой хөгжлийн суурь дэд бүтцийг бий болгох 14 мега төслийг 2025 онд багтааж бүрэн эхлүүлэх, макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, зах зээл дэх төрийн оролцоог хялбарчлах, салбаруудад бодлогын цогц реформыг хийх ажлуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, эрчим хүч, зам тээвэр, хөдөө аж ахуй, банк санхүүгийн салбарт бодлогын цогц шинэчлэл, либералчлалыг хэрэгжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. Уул уурхайн салбарт тусгай зөвшөөрлүүдийг ил тод болгож, Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр		
--	--------------------------	--	--	--	--	--	---	--	--

							арилжаалдаг бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, биржийн тогтолцоог бэхжүүлнэ. Мөн шинжлэх ухаан, технологи, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг үе шаттай ахиулах бодлогыг хэрэгжүүлнэ. Дижитал эдийн засаг, ногоон эдийн засгийг бодитой нутагшуулж, Старт- Ап, инновацыг дэмжих бодлого, хөшүүргийг тодорхойлж хэрэгжүүлэх юм.		
1.2.8	Судалгаа, шинжилгээ хийх чиг үүрэг бүхий Үндэсний хөгжлийн хүрээлэн байгуулж, үйл ажиллагааг эхлүүлнэ.	-	Үндэсний хөгжлийн хүрээлэн байгуулсан байх	-	-	Үндэсний хөгжлийн хүрээлэн байгуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн байна.	Судалгаа, шинжилгээ хийх чиг үүрэг бүхий Үндэсний хөгжлийн хүрээлэнг байгуулж, тус хүрээлэн нь ажиллагааг эхлүүлээд байна. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны 10 дугаар	100%	100%

							сарын 28-ны өдрийн Б/23 дугаар тушаалаар Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захирлаар Г.Дэнзэнг томилсон. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 22 дугаар тогтоолоор Хүрээлэнгийн бүтцийг 5 нэгжтэй, 35-аас илүүгүй орон тоотой байхаар баталсан. Хүрээлэнгийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг боловсруулахад шинээр томилогдсон захиралд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.		
1.2.9	Олон улсын хөгжлийн туршлага, чиг хандлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулж, нэвтрүүлнэ.	-	Судалгааны тоо /Тоо/	-	-	Олон Улсын хөгжлийн туршлага, чиг хандлагын талаар судалгаа хийсэн байна. /Нийт 1 судалгаа/	Дэлхийн улс орнуудын хөгжлийн туршлага, чиг хандлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулах ажлын хүрээнд улс орнуудын хөгжлийн чиг хандлага, туршлагыг судалж байна. Тухайлбал, БНСУ, БНХАУ,	100%	70%

							Киргиз, Казахстан, ОХУ болон Турк Улсын хөгжлийн чиг хандлага, туршлагыг судаллаа. Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/96 дугаар тушаалаар "Дэлхийн улс орнуудын туршлага, хөгжлийн чиг хандлагыг судалж, баримт нотолгоонд суурилсан, дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлогын зөвлөмж гаргах" судалгааг хийж гүйцэтгэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсан.		
1.2.10	Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай технологи судлах, нутагшуулах, хөгжүүлэлтийг дэмжинэ.	-	Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай технологи судалсан байх	-	-	Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай технологи судалсан байна.	Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай технологийг судалж байна. Хөгжлийн нэгдсэн бодлог, төлөвлөлтийн газар нь хөгжлийн бодлого боловсруулах үйл явцыг үр дүнтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй болгох зорилгоор технологи	100%	70%

							нутагшуулах, хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд хиймэл оюун ухааныг ашиглан бодлогын шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг тодорхойлох судалгаа хийж байгаа бөгөөд энэхүү ажлын хүрээнд холбогдох мэргэжлийн чиг үүрэг бүхий 3 компанитай уулзан харилцан үр дүнд хүрэхээр ажиллаж байна		
1.2.11	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, мэдээллийг эргэлтэд оруулна.	-	Хэрэгжилтийн явц, хувиар	-	Улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сан байгуулах асуудлыг судалсан байна.	Улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сан байгуулах асуудлыг судалсан байна.	Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар нь Монгол улсын хөгжлийн төлөвлөгөөг бодлогын хэрэгжилттэй нь уялдуулах, яамд, байгууллагуудын уялдааг хангах зорилгоор нийтийн мэдээллийн санг байгуулахаар ажиллаж байна.	100%	70%

Үнэлсэн:

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

(албан тушаал)



/И.БАТХҮҮ/

(гарын үсэг)

2024.12.18

(огноо)

Тайлагнасан:

Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын

Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга..... /Л.Балчинлуvsан/

(албан тушаал)

(гарын үсэг)

2024.12.18

(огноо)